ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.11.22 **Дархан-Уул аймаг**

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөлийн чиглэл

- Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем болох www.egazar.gov.mn, газрын харилцааны цахим шилжилт, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу төрийн болон аж ахуйн нэгж байгууллагад батлагдсан хуваарийн дагуу танилцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан.
- 2022 оны Дархан сумын Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллаж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Дархан сумын 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын төлөвлөгөө

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Төлөвлөгөөнд нийт 137 санал ирсэн. Үүнээс: ААНБ болон төрийн байгууллагаас 6, иргэн 131 санал ирсэн

№	Бүртгэлийн дугаар	Хүсэлт гаргасан ААНБ, иргэний нэр	Хуудасны дугаар	Зориулалт	Байршил	Танилцуулага
Ирсэн албан тоот, ергөдөл						
1	21-23	Ш.Энхтэлш	12	Мод үржүүлэг	Матчин баг Уужим булаат	өмнө нь БОАЖГ -аас 3 гэрээгээр эзэмшиж байсан. Төлөвлөгөөнд тусгаж эзэмших хүсэлт өгсөн/
2	21-170	Дархан сумын Засаг дарга	6	Хүүхэмж	13-р багт өөрийн эзэмшэл газар	Иж сургуулийн 5-15 тоот газар дээрээ нэмж авах тухай
3	21-668	Дархан сумын Засаг дарга	8	Сувилахуйн тев /Эрүүл мэндийн байгууллага/		Монгол Улсын ИХ-ын пшуун Г.Давданнав /Монгөөн нандин хэлхээ ХХК нь сувилахуйн тев байгуулах хүсэлт өгсөн/
4	21-853	Авто тээвэрлэн тев	4			санал ирээгүй
5	21-868	Хунс хядаа ак ахуйн газар	4	Авто машины зогсоол		Авто машины зогсоолыг эзэмшэл газар дээрээ нэмж авах тухай санал өгсөн.
6	21-901	Дархан-Ус сувог ХК	1	Зуслангийн зориулалттай	Хонгор сумын Зуузаын голд	Чандмань- Эрдэнэ аварлтын газрын нь бүтэн байгуулалт нийсэд хүрэлцэхгүй байгаа тул газрыг нэмж төлөвлөөнд тусгах тайлбар санал өгсөн
7	9/20/2021	Эрүүл мэндийн байгуулагуудын үйлдвэрчний эвлэлийн хороо	13	спорт заал	Эрүүл мэндийн газрын өөрийн эзэмшэл газар дээрээ	ажилтнуудадаа зориулж спорт заал барих санал өгсөн

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар:

- Дархан-Уул аймгийн 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйс бүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- Дархан сумын 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд санал өгөх QR кодыг мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтны хамтран бэлтгэж иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад танилцуулсан. Нийт 113 иргэн санал өгсөн байна

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлийн чиглэлээр:

- Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан.
- Аймгийн хэмжээнд 2022 онд 445 иргэнд 33,94 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөж аймгийн Иргэдийн төлөөлөгдийн хурлын тэргүүлэгдийн 2021 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн 69 дүгээр тогтоолоор батлагдсан. Тус ажлыг сумын газрын даамлуудтай хамтран зохион байгуулан ажилласан.
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 9 иргэнд лавлагаагаар үйлчилсэн.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны чиглэлээр:

- Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан болон дүгнэлтийг Газрын мониторингийн цахим системээр Гранд Амур ХХК, Эхлэх цэг хангай ХХК-ийн гүйцэтгэсэн 12 тайлан дүгнэлтийг шалгаж мониторингийн цахим системээр баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Салайм ХХК, Үзмон ХХК, Дээшлэх говь ХХК, Глобус ХХК-ний цахимаар ирүүлсэн 6 тайланг шалгаж засварлуулахаар буцаасан.
- Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх өмчлөлийн 5, эзэмшлийн 6 иргэнд хянан баталгаа хийлгэх тухай мэдэгдэх хуудсыг хэвлэж өгсөн.
- **Газар хамгаалах нөхөх сэргээх чиглэлээр:**

  Аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газрын уул уурхай асуудал хариуцсан мэргэжилтэн Баямөнх, Аймгийн мэргэжлийн хяналтын геологи, уул уурхай хариуцсан мэргэжилтэн Учрал нартай хамт шийрийн бригадын орчим хуучин ухагдаж эвдэрсэн газарт дүйцүүлэн хамгаалалтаар техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын 2021.11.09-ны өдөр очиж шалгаж, хэмжилт хийж, фото зургаар баримтжуулж авсан. Мөн 2021.11.10-ны өдөр Аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын мэргэжилтэн Баямөнхийн хамт Дархан Азза ХХК-ий хийж буй 25, 31-р хорооллыг 6, 7 дугаар багийн гэр хорооолтой холбох замыг тавьж байхад хуучин ухагдаж эюдэрсэн газрыг томруулж нэмэж ухаж эвдсэн газар дээр очиж хэмжилт хийж, фото зургаар баримтжуулах ажлыг хийсэн.
- **ЭБАТ-ын чиглэлээр:**

  Ерөнхий нягтлан бодогчоор нэр дэвшсэн албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийн хянуулахаар 2021.11.11-ны өдрийн 680 тоот албан тоотоор, мөн АТГ-ын цахим бүрдүүлэлтийн системд урьдчилсан мэдүүлгийн бөглөж баталгаажуулах хийж, цахимаар урьдчилсан мэдүүлгийн хянуулахаар хүргүүлсэн.

`

Газрын татвар, төлбөрийн чиглэл:

- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021.10.22-ний өдрийн 01-А/292 дугаар захирамжаар Дархан сумын 8, 12, 13-р багийн нутаг дэвсгэрт 6 нэгж талбарт худалдаа, үйлчилгээ, ХАА-н бусад үйлдвэрлэлийн зориулалтай газрыг Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ээр газрын дуудлага худалдааг 2021.11.12-ний өдөр зохион байгуулахаар газрын байршил, зориулалт, талбайн хэмжээ, дуудлага худалдааны анхны үнийг баталсан. Тус захирамжийн дагуу дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2021.11.09-ний өдрийн 01-А/315 дугаар захирамжаар байгуулагдсан. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг 2021.11.05-2021.11.11-ний өдрийн 15:00 цаг хүртэл буюу ажлын 5 өдөр цахимаар хүлээн авсан бөгөөд 2021-7906 нэгж талбарт 2 хүсэлт ирж дуудлага худалдаа зохион байгуулагдлаа. Үүнд**:**
- **Газрын байршил: 2021-7906-1000м.кв**

  Дуудлага худалдааны анхны үнэ: 25 200 000 төгрөг,

  Дархан сум 12-р баг 31-р хороолол, Барилгачдын өргөн чөлөө 57-р гудамж 5700 тоот хаягт байрлах газарт:

1. 21236 оролцогчийн дугаартай **Г.Сарантуяа /РД:ТБ88032607/** нь хамгийн өндөр үнийн санал ирүүлж **35 200 000 төгрөгөөр ялагч боллоо.** Дуудлага худалдааны ялагчтай байгуулах гэрээг 2021.11.15-ний өдөр байгуулсан.
2. 21282 оролцогчийн дугаартай оролцогч Г.Болдпүрэв /РД:ТК96041119/ нь 34 200 000 төгрөгийн үнийн санал ирүүлж ялагдлаа.

- **Газрын байршил**: **2021-7906-1000м.кв газарт 35 200 000** төгрөгийг газрын дуудлага худалдааны орлогод төвлөрүүлэхээр боллоо.
- Бусад 2021-7904, 2021-7907, 2021-7908, 2021-7909, 2021-7910 дугаартай нэгж талбарт оролцогч ирээгүй тул дуудлага худалдаа хүчингүй боллоо.
- Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх комиссын хуралд 18 иргэний гаражийн өргөдлийг цахимаар хүлээн авч хурлын материал бэлтгэсэн.
- Дархан сумын 13-р баг, 29-р хороллын газар эзэмшигчдийн судалгаа /11 аж ахуйн нэгж, 7 иргэн/-г гаргаж, газрын төлбөрийн тооцоо гаргасан.
- Орхон суманд 9 нэгж талбарт газрын дуудлага худалдаа 2021.12.10-ны өдөр, Хонгор суманд 10 нэгж талбарт газрын дуудлага худалдаа цахимаар 2021.12.17-ний өдөр тус тус болохоор Газрын цахим биржийн системээр зарлагдсан.

Газрын төлбөрийн орлого:

2021.11.18

	Аймаг	743,148,848.47
2	Дархан	267,733,970.86
3	Хонгор	92,172,137.57
4	Орхон	10,901,130.00
5	Шарын гол	22,923,638.20
НИЙТ		**1,136,879,725.10**

- Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2020, 2021 оны хүлээгдэж байгаа нэхэмжлэл, мөнгөн дүнгийн судалгааг гаргаж өгөв.

Сумдын нэрс	**2020 он**	**2021он /хүлээгдэж буй дүн/**	**Нэхэмжлэгчийн тоо**
Дархан	270,504,596	737,767,825	6027
Орхон	4,795,856	8,936,651	866
Хонгор	39,838,057	121,788,767	3102
Шарын гол	5,386,764	55,170,666	381
Нийт	**320,525,273**	**923,663,909**	**10376**

Геодези, зураг зүйн чиглэл:

- Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од", "Ёлт сүрвэй" ХХК-ний хийж гүйцэтгэсэн **13** ажлыг шалгаж хүлээн авсан.
- ГЗБГЗЗГ-аас хилийн цэсийн маргааны судалгааг ирүүлэх тухай 2/2009 дугаар албан бичгийн дагуу хилийн цэсийн маргаан гараагүй тухай Орхон сум №401, Шарын гол сум 01/461 дугаар албан бичгээр хариу ирүүлсныг нэгтгэн ГЗБГЗЗГ-т албан бичгээр хүргүүллээ.
- Хонгор сумын хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумтай хилийн цэсийн /Хонгорын даваа/ маргаантай байсан бөгөөд уг асуудалыг Монгол улсын Ерөнхий сайдын 2018 оны 89 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдөр хуралдаж Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын хилийн цэсийн маргаантай асуудлыг авч хэлэлцээд Дархан-Уул аймгийн Хонгор сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумтай хиллэх "Хонгорын даваа" эргэлтийн цэгийг газар зүйн байрлалын хувьд "даваа"-н дээр байрлалтай байгаа эргэлтийн цэг /49.29.00.5, 106.40.42.8/ -ээр мөрдөх /Ерөө сумын талд/ шийдвэр гарсан байдаг.
- Гэвч орон нутгийн удирдлагууд уг асуудлыг маргаантай байгаа гэж үзсээр байгаа бөгөөд Хонгор сумын Засаг даргаас 2021 оны 11 сарын 22-ны өдөр ирүүлсэн №1/923 дугаар албан бичигт "маргаантай" гэсэн хариуг ирүүлсэныг ГЗБГЗЗГ-т уламжиллаа.

- Газар өмчлөх эрх шилжүүлсэн **21** иргэний бүртгэл хийж **9** амины орон сууцыг кадастрын зурагт оруулсан. Шинэчлэн бүртгэлд хамрагдаагүй **15** иргэн **8** аж ахуй нэгжийн эзэмшил, өмчлөлийг газрыг ажлын нэгж талбарт шилжүүлсэн.
- Хаягийн зургийн дагуу **23** иргэн, **2** аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- Багуудын ИНХ-ын дарга нартай хийсэн уулзалт зөвлөлөгөөнд оролцож багуудыг оноосон нэртэй болгож УИХ-аар баталуулах тухай мэдээлэл хийсэн. Үүний дагуу 1,3,10,14,16 дугаар багууд багийн ИНХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаа хийж багийн оноосон нэрийн саналаа ирүүлээд байна.
- 10 дугаар сарын 28-ны өдөр 9:00-17:30 цагийн хооронд “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн мэдлэг олгох“ цахим сургалтанд хамрагдсан.
- Газар зүйн нэрийн мэдээллийн санг хөтлөх ажлын хүрээнд Монгол Улсын их хурлын 42 дугаар тогтоолоор батлагдсан Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг геопортал дээр засварлах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Сумдын тайлан

Хонгор:

- Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлжх тухай 16, талбайн хэмжээ өөрчлөх тухай 8, Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай 3, Хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, шинээр газар өмчлөх эрхээ сэргээлэхийг хүссэн 1 нийт 28 иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч сумын Засаг даргад танилцуулан захирамжийн төсөл боловсруулан шийдвэр гаргуулсан. Дээрх шийдвэрийн биелэлтийг 100 % биелүүлсэн байна.
- 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд туссан газрын дуудлага худалдааг зохион байгуулах тухай сумын Засаг даргын захирамж шийдвэрийг гаргуулсан. Дээрх шийдвэрийн дагуу 2021 оны 12 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Вэб программ дээр э дугаар унасан нийт 116 ИААНБ-ын газрын цахим гэрчилгээ үүсгэж гэрээ байгуулсан байна.
- Молын гоц халдварт өвчин болох шүүлхий өвчин тус сумын 2 багийн нутаг дэвсгэрт гарсантай холбогдуулан 6 дугаар бригад орчимд 24 цагын постонд хуваарийн дагуу гарсан. Мөн дээрх өвчинтэй холбогдуулан 1сумын 1,2,3 дугаар багийн нутаг дэвсгэрийн газрын зураг болон ажлын зургийг гаргаж өгсөн байна.
- Сумын дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмал олобрлож буй Бичигт хад майнинг, Барилга орд ХХК-ний нөхөн сэргээлт хийж буй ажилыг нь сумын нөхөн сэргээлт хүлээж авах комиссын бүрэлдхүүнтэй газар дээр нь очиж танилцсан. Дархан-Шарын гол чиглэлийн авто замын трасст орсон 8 ИААНБ-руу утасдаж тус замын ажлыг саадгүй хийх, замын трасст орсон газруудаа чөлөөлөх тал дээр утасдаж мэдэгдсэн.

- Сумын 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөн нэмэлт тодотголоор оруулахаар ирүүлсэн 259 санал хүсэлтийг нэгтгэж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаалр хэлэлцүүлсэн. Мөн дээрх санал өргөдөл хүсэлтйг нэгтгэн 197 иргэний өргөдөл хүсэлт саналыг нэгтгэж төлөвлөгөө боловсруулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил талбайн хэмжээг тогтоох тухай тогтоолын төслийг бэлдэж мөн хурлаар хэлэлцүүлсэн болно.

Орхон:

- Орхон сумын 2021 оны тухайн жилийн төлөвлөгөөний дагуу сумын засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/154 тоот захирамжаар нийт 9 байршилд газрын цахим дуудлага худалдаа зарласан. Мөн газар өмчлөх тухай 104, өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 5 , зориулалт өөрчлөх 2, газар эзэмших эрх шилжүүлэх 3, газар ашиглуулах тухай 1, цахимаар өмчилсөн газар худалах худалдан авах гэрээ 6, газрын барьцаанд бүртгүүлэх 1 нийт 122 өргөдлийг шийдвэрлэлээ.
- 2022 оны Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний саналыг авч дууссан ба гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар-23, худалдаа үйлчилгээний газар-3, зоорь-3, ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор газар-10, Өвөлжөө хаваржаа-19, Төмс хүнсний ногоо-5, Тэжээлийн ургамал-3, Аялал жуулчлал-1, Мэдээлэл холбоо дамжуулах шугам-1, Мод үржүүлгийн газар-3, Жимс жимсгэнэ-1 нийт 72 санал авч газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө боловсруулж байна.
- Газрын гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 41 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилсэн. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор “Орхон сум”-ын хаягийн зураг батлуулсан. Үүнд: Баян-өлзийт багийн Залуучуудын гудамж, Шар дэрс, Зөгийн дэнж, Дэнж, Дэлгэр хороолол, Богчийн дэнж, Тосгон, Ерөө, Энхтал багийн Ноёнхонгор, Их булангийн хөндий, 96-р зөрлөг зэрэг нийт 24 гудамж, 347 нэгж талбарт шинээр хаяг өгсөн байна. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдын 2018 оны 25 тоот тогтоолоор батлагдсан шинэ хаягийн дагуу 5 иргэнд шинэ хаяг өгч ажиллаа. Мөн газрын өргөдлийг цахимаар хүлээн авдаг болсонтой холбоотой цахимаар 6 өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн.
- Сумын засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/154 тоот захирамжаар нийт 9 байршилд 26.889.400 төгрөгийн газрын цахим дуудлага худалдаа зарласан байна.
- Газрын цахим хаяг болох www.mle.mn сайтад дуудлага худалдааны 9 байршлын мэдээллийг байршуулсан.
- Суманд малын шүлхий өвчин гарсантай холбоотой шүлхий өвчний голомтын бүс болон сэжигтэй бүсийг тогтоож зураглал үйлдсэн.

Дархан сум:

- Өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 9 , Хамтран өмчлөх эрх хүчингүй болгох 29, газар эзэмших эрх шилжүүлэх 5, цахимаар өмчилсөн газар худалах худалдан авах гэрээ 33, Э-дугаар авч гэрчилгээ бичсэн 14 нийт 90 өргөдөл шийдвэрлэлээ. Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх комиссын хуралд эзэмших 9 иргэн, Өмчлөх 104 иргэний материал бэлтгэсэн.
- Газрын гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 28 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилсэн.
- Шинэчлэн бүртгэлд хамрагдаагүй 15 иргэний эзэмшил, өмчлөлийг газрыг бүртгэсэн.
- Хашаа сунгасан 5 иргэнд шаардах хуудас хүлээлгэн өгч ажилласан.
- Дархан сумын 13-р баг, 29-р хорооллын газар эзэмшигчдийн судалгаа /11 аж ахуйн нэгж, 7 иргэн/ гаргаж, газрын төлбөрийн тооцоо гаргасан.
- Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны дүгнэлтын 3 иргэнд хэвлэж өгсөн.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Барилгын хяналт шалгалт:

- Шинээр батлагдсан Засгийн газрын 212-р тогтоолын дагуу барилга ашиглалтад оруулах комиссыг 3 байршилд зохион байгуулж ажилласан. Үүнд:
    - Монгол Улсын засгийн газар, Бүгд найрамдах Австри Улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээний дагуу хийгдсэн Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Орхон сумын 315 ширхэг гэрэлтүүлэг
    - Дархан-Уул аймгаг, Орхон сум, Иргэн Наранцэцэгийн малын бой, нядалгааны барилга
- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл аваагүй барилга угсралтын ажил явагдаж байсан 2 барилга байгууламжид зөрчлийг арилгуулах тухай албан бичгийг өгсөн. Үүнд:
    - Дархан сум, 13-р баг, “Хатан дулам” ХХК-ний эмнэлэгийн барилга
    - Дархан сум, 12-р багт, “Цуурай цо” ХХК-ний үйлчилгээний барилга

- Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р багт байршилтай улсын төсвийн хөрөнгө оруулалттаар “Жинсийн орой” ХХК-ний барьж ашиглалтад оруулсан 27-р цэцэрлэгийн өргөтгөлийн 150 хүүхдийн цэцэрлэгийн гадна хаяавч бетоны доогуур нүх үүсч хөндий зай гарсан, цоклийн плита ховхорч унасан тул гүйцэтгэгч байгууллагад нь хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр хүргүүлсэн.
- Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анханы шатны шүүхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Дархан сумын 9-р багт байрлалтай “Минж проперти” ХХК-ний нийтийн орон сууцны талаарх мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн.
- Дархан сум, 9,10-р багт 31-р хорооллын амины орон сууцны инженерийн шугам ашиглалтад оруулах хүсэлт ирүүлсэний холбогдох барилгын техникийн бичиг баримт дутуу байсан тул албан бичгийг хүргүүлсэн.
- Миний монгол цэцэрлэгт хүрээлэнгийн Хөлбөмбөгийн талбайн тохижилтийн ажил гүйцэтгэгч “Вилла бридж” ХХК-д барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон.

Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж ХОХБТХ-т хүргүүлсэн.
- Ковид 19 цар тахалтай холбоотойгоор шинжилгээний цэгт ажилласан.
- Захиалагчийн техник хяналтын хүрээнд 6,7-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажилд хяналтыг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын хуралд танилцуулсан.
- Дахин төлөвлөлтийн хүрээнд Дархан сумын 5,6-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх брак байруудын тойм зургийг гүйцэтгэсэн. Мөн Дархан сумын 3-р баг Цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн талд багийн төв барихтай холбогдуулан ерөнхий төлөвлөгөөний зураглал хийж гүйцэтгэсэн.
- Дархан сумын 8-р баг Ус суваг ХК газарт баригдахаар төлөвлөж буй Цагдаагийн газрын барилгын зураглал хийж Дархан-Ус суваг ХК-ын удирдлагуудад танилцуулсан.
- УБТЗ ХНН-ийн Хүүхдийн төмөр зам ашиглалтад оруулсантай холбоотой техникийн бичиг баримтыг шалгаж архив хүлээлгэн өгөх зөвөлгөө өгсөн.

- Барилга хөгжлийн төвийн нийтийн аж ахуйн мэдээллийн сан ашиглалтад оруулсантай холбогдуулан Дархан сумын СӨХ-ийн мэдээлэл болон хог ачилтын машины судалгааг оруулсан. Мөн инженерийн хангагч байгууллагуудаас холбогдох мэдээллийн авахаар албан тоот хүргүүлсэн.

Хот байгуулалтын төлөвлөлт, зураг төсөл

- Архитектур төлөвлөлтийн даалгавар цахим системээр 4 аж ахуй нэгжид хүргүүлсэн.
- Байршилын зураг 7 зураг төслийг гүйцэтгэсэн.
- Дахин төлөвлөлтийн хүрээнд барилгажих боломжтой 3,7,8,15 дугаар багийн байршлын зураг Дархан суманд цахимаар хүргүүлсэн.
- Covid19 түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд ажилласан.
- БСУГ-н захиалагт 320 хүүхдийн сургуулийн архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж өгсөн.

Барилгын материал үйлдвэрлэл

- Дархан сум 12-р баг 24-р хороололын 55 айлын газрын байршлын зураг хийж гүйцэтгэв.
- 2021.09.21-ний №523 албан тоотоор хүргүүлсэн мэдэгдлийн хэрэгжилтийг шалгасан. 14-р хорооллын 115 газар эзэмшигч нарын 96 айл буюу 83% хашаа барьсан байна.





- 24-р хорооллыг Газар эзэмшигч нарыг газар ашиглалтыг эрчимжүүлж аймгийн ГХБХБГ-ын 2021.11.01-ний №662 албан тоот болон нэгдсэн нэг загварын хашаа хийх шаардлага тавьж мэдэгдэл олгосон.
- Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК технологийн заавар болон тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ авах шаардлага тавьлаа. БХБСайдын 2021 оны 147 тоот тушаалыг танилцуулж суурь нөхцөл шаарлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх тухай мэдэгдэж, тусгай зөвшөөрөлийн хүсэлтийн маягтыг файлаар өгсөн.
- Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах, дахин олгоход www.mcis.gov.mn сайтад бүртгүүлэх гарын авлагыг танилцуулсан.

3. ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛ:

Шүүх:

- Гуравдагч этгээдийн /Ласти интернашн ХХК/ оролцогчын бие даасан шаардлагын хүрээнд “ Улсын комиссын актыг хүчингүй болгуулах” нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн хариуцагчаар Газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах, С.Ундрах нарт холбогдох хэрэгт Захиргааны хэргийн шүүхийн хурал 2021/11/02-нд болсон. Шүүхээс Гуравдагч этгээдийн бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.
- Нэхэмжлэгч “Шинэ үе хамтын холбоо” ТББ-ын нэхэмжлэлтэй, хариуцагчаар Аймгийн Засаг дарга, хамтран хариуцагчаар ГХБХБГ-ын дарга нарт холбогдох Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаартай шүүхээс шийдвэрийг нэхэмжлэх талаас гомдол гарсны дагуу Нийслэлийн захиргааны хэргийн шүүхээс Нэхэмжлэгч талаас өмгөөлөгчөө солих хүсэлт гаргасны дагуу 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн шүүх хуралдааныгхойшлуулсан.
- Нэхэмжлэгч тал болох Дархан сумын 9-р баг, 4 хороолол 4- байрны оршин суугчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч н. Б.Жаргалсайхан, Ц.Батцацрал нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн хариуцагчаар Аймгийн ЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах, С.Дарханбаатар, Гуравдагч этгээдээр “Минж проперти” ХХК нарт холбогдох захиргааны хэргийн шүүх хуралдаан 10 дугаар сарын 28-нд 10:00 цагт болж Нэхэмжлэгчийн шаардлагыг хангуулхаар шүүх шийдвэрлэсэн.

Хууль тогтоомж:

- Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021/10/05-ны өдрийн №2/1895 албан тоотын дагуу ирүүлсэн ГЗБГЗЗГДаргын А/187 тоот тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад танилцуулсан. Иргэдийн газрын талаарх цахим системийг ашиглахад нь зориулж “**ЦАХИМ ТӨВ**” нээн ажиллуулж заавар зөвлөгөө, өгөх, албан хаагчдын хуваарийг батлан мөрдүүлж ажиллаж байна.



- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг албан хаагчдад танилцуулж, 11 дүгээр сарын 15-нд агентлагт хуулийн төслийн дэмжиж, саналгүй гэсэн албан тоотыг хүргүүлсэн.

Сургалт:

- Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институтын Богино хугацааны сургалтад хамрагдах нэг албан

хаагч, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад хамрагдах нэг албан хаагчийн судалгааг tsenayushnyamaa@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.

- 2021 оны 11 дүгээр сарын 15,16-нд өдөр Агентлагаас зохион байгуулах “Авлигын эсрэг” сэдэвт сургалтад хамруулхаар албан хаагчдын нэрсийг цахимаар enkhtuya23.d@gmail.com хүргүүлсэн.
- Удирдлагын академийн богино хугацааны “ Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтад хамрагдах албан хаагчийн судалгааг аймгийн ТЗУХэлтэст able цахимаар хүргүүлсэн.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан “Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах нь” сэдвээр Ж.Эрдэнэбат цахимаар сургалтын хийж, 2 албан хаагч хамрагдсан.
- 2021 оны 11 дугаар сарын 23 -ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах арга зүй” сургалтанд Орхон, Хонгор, Шарын гол Дархан сумы газрын даамлууд оролцсон.



- “Жендэрийн статистик ба тогтвортой хөгжлийн үзүүлэлт түүнийг ашиглах нь” сэдвээр Үндэсний статистикийн хорооноос аймгийн төрийн байгууллагуудын хүний нөөц, нийгмийн ажилтан нарт зохион байгуулсан танхимын сургалтад оролцсон.
- 2021 оны 11 дугаар сарын 17 -ны өдрийн 8:00 цагаас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Гэр бүлийн харилцааг сайжруулах” сургалтанд нийт 8 албан хаагч хамрагдсан.

- АЗДТГ-аас зохион байгуулсан “Олон нийтийг соён гэгээрүүлэхэд ТБ-аас түгээх мэдээлэл, сурталчилгааны нөлөөлөл” сэдэвт сургалтанд мэргэжилтэн Э.Түмэнжаргал хамрагдлаа.

- Нийтийн албан тушаалтнуудад зориулсан Авлигын эсрэг анхан шатны сургалтын хөтөлбөрийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 15-22-ны хооронд ZOOM Meeting ID 842 4557 5667, Passcode 1108, АТГ-ын албан хаагч А.Цэдэн-Иш, Д.Золжаргал, Г.Ундармаа, С.Баярцэцэг, Б.Тэрбиш, Д.Балдандорж нар цахимаар сургалтыг зохион байгуулж байгууллагаас 17 албан хаагч болох газрын даамал, мэргэжилтэн, удирдлагууд хамрагдсан.



- Газрын Удирдлагын хэлтсийн даргын батлуулсан Egazar.gov.mn цахим системийг сурталчилан, сургалт мэдээлэл хийх хуваарийн дагуу 16 төрийн байгууллагаад 4 албан хаагч өдөр бүрээр мэдээллийг хүргэж ажиллаж байна. Газрын харилцаа-Цахим шилжилт аяны хүрээнд Гаалийн газрын 19 албан хаагчдад Газрын нэгдмэл сангийн систем, Газрын биржийн цахим системийн сургалтыг мэргэжилтэн Ц.Чулуунцэцэг, Шүүхийн тамгын газар 14 албан хаагчид, Ус цаг уур, орчны шинжилгээний газарт 18 албан хаагч, хийсэн.
- 2021 оны 11 дугаар сарын 17 -ны өдрийн 8:00 цагаас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас “Хүмүүжлийн эерэг аргыг түгээе” аянын хүрээнд зохион байгуулсан сургалтанд нийт 8 албан хаагч хамрагдсан.

- www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг Мэргэжилтэн Б.Баярмаа нь орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевиз, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Шүүхийн тамгын газарт нийт 41 албан хаагчдад танилцуулсан байна.

Бусад тайлан:

Үүрэг даалгавар:

- 2021 оны 11 дүгээр сарын 01-07 хооронд 7 хоногийн хугацаатай ГХБХБГ-аас ковидын шинжилгээний төлбөр, бүртгэл дээр суух албан хаагчдын хуваарийг баталж, тухайн өдрүүдэд томилогдсон албан хаагчид үүргийг гүйцэтгэж ажилласан.



- 3-р тунд хамрагдах албан хаагчдын судалгааг гаргаж Дархан сумын ЗДТГ-т хүргүүлсэн.

- Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2020-2021 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбрийн мэдээллийг хүснэгтийн дагуу Аймгийн ЗДТГ-т 26-нд хүргүүлхээр хяналтад авлаа.
- 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 2-10/1352 албан бичгийн дагуу аймгийн ЗДТГ-ын ХЭЗХэлтэсээс ирүүлсэн Давхар ажил эрхлэлт, болон ХАСУМ-г АТГ-т хүргүүлж хянуулах, ажилд томилсон байдалд судалгаа хийх, ЭБАТ-ны дэлгэрэнгүй мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 29-нд хүргүүлхээр хяналтад авлаа.
- 13 иргэн, хуулийн этгээдэд “Сонсох ажиллагааны мэдэгдэл” боловсруулан хүргүүлж ажилласан.

Мэдээлэл технологи, нярав:

- 70376471 нээлттэй утсаар 26, Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын фэйсбүүк хуудсанд ирсэн 21 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.
- Номын сангийн программ хэрэглэгчдийн хугацааг сунгаж, ажлаас чөлөөлөгдсөн 3 албан хаагчийн мэдээллийг устгаж, 2 албан хаагчийг шинээр бүртгэв. Хэрэглэгчдийн картуудыг шинэчлэн хэвлэв.



BOR_ID	NAME	BARCODE	TYPE	STATUS
101	Мөнхчулуун	G001	Worker	Active
102	Төмөр	B001	Worker	Active
103	Анхбаяр	G002	Worker	Active
104	Батчулуун	Z007	Worker	Active
105	Базарсад	G004	Worker	Active
106	Чулуунцацгэ	G005	Worker	Active
107	Баярмаа	G006	Worker	Active
108	Мөнхзул	Z001	Worker	Active
109	Үүрийнтуяа	G007	Worker	Active
110	Мягмарсүрэн	G008	Worker	Suspended
111	Нямдорж	G009	Chief	Active
112	Олонбаяр	B002	Chief	Active
113	Гантуяа	G010	Worker	Active
114	Ролжинжав	Z002	Worker	Active
115	Мөнгөнтогос	B003	Worker	Active
116	Цэнд-Аюуш	Z003	Worker	Active
117	Ганбаяр	Z004	Worker	Active
118	Түвшинжаргал	Z005	Worker	Active
119	Үндрах	B004	Worker	Active
120	Золбаясах	Z006	Worker	Active
121	Дарханбаатар	B005	Worker	Active
123	Гүрхэнд	G011	Worker	Active
124	Болорцацгэ	G012	Worker	Active

- Дархан сумын газрын даамалд бичигдсэн гэрчилгээнүүдийг цэгцлэхэд туслаж 222 ширхэг өргөдлийг дараалалд оруулж өгөв.

- Байгууллагын цахим хуудсан дээрх 6 мэдээлэл, Төрийн үйлчилгээ цэсний Хураамж дансны мэдээлэл хэсэгт шинэчлэгдсэн хураамжийн мэдээллийг засварлан байгууллагын 10-р сарын 1, 2, 3, 4-р долоо хоногийн ажлын тайлан, 10-р сарын ажлын тайлан, 10-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Дархан суманд зарлагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар, Орхон суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар, Хонгор суманд газар эзэмшүүлэх дуудлага худалдааны зар, Түргэвчилсэн оношлуурын шинжилгээний бүртгэл дээр

ажилласан тухай мэдээлэл, Дархан сумын 2021 оны дуудлага худалдааны мэдээллийг байрлуулав.



- Байгууллагын Facebook хуудсанд Дархан суманд зарлагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар, Орхон суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар, Хонгор суманд газар эзэмшүүлэх дуудлага худалдааны зар, Дархан сумын 2021 оны газар эзэмшүүлэх дуудлага худалдааны мэдээлэл, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Гаалийн газар, Шүүхийн тамгын газрын албан хаагчдад Egazar цахим систем танилцуулсан тухай мэдээлэл, хүмүүжлийн эерэг аргыг түгээе аянд ГХБХБГ нэгдсэн тухай мэдээлэл, Түргэвчилсэн оношлуурын шинжилгээний бүртгэл дээр ажилласан тухай мэдээлэл, Архитектур төлөвлөлтийн даалгавар цахимаар авах зааврын видео, Хүүхдээ цахим орчинд хэрхэн хамгаалах тухай постер 2 удаа, Улсын бүртгэлийн мэдүүлгийн хуудсыг egazar системээс хэрхэн авч, бөглөх талаар заавар оруулав.

- Байгууллагын болон сумдын даамлуудын фэйсбүүк хуудасны cover зургийн эхийг бэлтгэж солив. Байгууллагын цахим хуудасны нөөцлөлтийг 2021-10-31-ний өдрийн байдлаар хийв.

- Нэг албан хаагчийн цахим шуудангийн нууц үгийг сэргээж өгөв. Шинээр ирсэн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч шалган, мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгч хэвлэгч, сканерыг таниулж өгөв. Цахим төв, Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтний компьютерт хэвлэгчийг таниулж өгөв. Kaspersky програмын шинэ хувилбарын тохиргооны талаар судалгаа хийж. Сүлжээний принтерүүдийн тохиргоог шинэчлэн хийв.

`



- Тоон гарын үсгийн төхөөрөмжийн хугацааг сунгуулах албан хаагчдын мэдээлэл болон гарын үсгийг төхөөрөмжийн хамт агентлаг руу илгээв.
- Абле системийн цаг бүртгэлийн програм ажиллахгүй байгаа тухай Абле системийн лавлах төвөөс лавлаж програмын шинэ хувилбарыг авч суулган ажиллуулав.

Нярав:

Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд дараах үнэт цаас тус тус олгов.

Сум	Кадастр	Газар эзэмших /Иргэн/	Газар эзэмших /ААНБ/	Газар эзэмших /ТБ/	Газар ашиглах /ААНБ/	НТХХ
Дархан	30					5

Шаардах хуудсаар 6 төрлийн 30 ширхэг бараа материал олгов. 10-р сарын үнэт цаасны зарцуулалтын болон шаардахаар олгосон бараа материалын нэгтгэлийг гаргасан.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

- ГХБХБГ-т 2021 оны 10 сарын 21-ний өдрөөс 11 сарын 20-ны өдрийн хооронд абле программд нийт 115 албан бичиг /хариутай 78/, 43 өргөдөл /хариутай 39/ ирсэнээс 71 албан бичиг, 22 өргөдөл шийдвэрлэн, 44 албан бичиг, 21 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.НЯМДОРЖ